



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 461

Улаанбаатар хот

Г  
Нийслэлийн нутгийн захиргааны  
байгууллагын үйл ажиллагаанд хяналт,  
шалгалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд үүсэж буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох, ажлын хариуцлага сахилга батыг өндөржүүлэх, иргэдэд үйлчлэх төрийн ажил үйлчилгээнд чанарын ахиц дэвшил гаргах, бодлогын зорилтууд, тогтоол шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулах зорилгоор нийслэлийн хэмжээнд дотоод үйл ажиллагааны хяналт, шалгалт зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газар (Ү.Ганболд)-т даалгасугай.

2. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шалгалт зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, дүүргийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын (хэвтээ) үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж, удирдлагагаа арга зүйгээр хангаж, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын дотоод үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтын тайлан, үр дүнг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Х. НЯМБААТАР



1725020231



ନେତ୍ରପାଦ ରାଜୀବ ଗାଁରୁ (୧୯୮୫ ମୁହଁରେ ନାମବିଚ୍ଛନ୍ନକାରୀ) - ୧୩ ମିନିଟ୍ ଲିପ୍ତିବିଦ୍ୟାରୀ ।

Digitized by srujanika@gmail.com on 2023-06-10

ମହିତ୍ୟାଚ୍ଛବି ରେ ପତ୍ର ଏବଂ କଲ୍ପନାରେ ।

2. ମାନ୍ୟମାନେ ଏବଂ କୁଳମାନେ ଏବଂ ପରିମାଣମାନେ ଏବଂ ପରିମାଣମାନେ ଏବଂ ପରିମାଣମାନେ

ପ୍ରାଚୀନ କାବ୍ୟରେ ମହାଦେଵ ଶିଖାରୀ ଏବଂ ପରାମର୍ଶଦାତା ହାତରେ ପାଇଲାମା ।

କାହାରେ କିମ୍ବା କାହାରେ ଏହି ପରିଚାଳନା କରିବାକୁ ବିଶ୍ଵାସ ନାହିଁ । କାହାରେ କାହାରେ ଏହି ପରିଚାଳନା କରିବାକୁ ବିଶ୍ଵାସ ନାହିଁ ।

1. മാത്രികൾ പുനരും പരിപ്പാവ് ദിവസമായി സംസ്ഥാപിക്കുന്നത് വരെ ഒരു കാലാവധി ചെറി മാത്രമാണ് എന്ന് പറയാം

22 ଟଙ୍କା ଟଙ୍କା ଏବଂ 22.5 ଟଙ୍କା ମିଳି ୧ ଫଲ ଫଲ ପାଇଁ ପାଇଁ ୨୦୦ ଟଙ୍କା ଏବଂ ୨୦୦ :

ଲାଗେ କ'ି 66.1 ଟଙ୍କି ମିଳୁରୁ । କିନିହିଁ ତଥାରେ କାହାମିନେ କାହାମିଲୁଛି ଏହିପରିବାରୁ କାହିଁ ଏହି କାହିଁ କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା

ବେଳେ / କରୁଣାମୂଳ୍ୟ / ଦେଖି ପାଇଲୁ / + କରୁଣାମୂଳ୍ୟ / ଦେଖି ପାଇଲୁ

ପ୍ରାଚୀନ ଏକାକୀ ଏବଂ ପାଦିତାମାତ୍ର ଥିଲୁଗାଟିକିରଣ କରି

$\omega_0 = \frac{1}{m} \sqrt{\frac{k}{m}}$

३०८

ଶ୍ରୀମଦ୍ଭଗବତ



ପାଇଁରେ  
କାହିଁବେ ଏବଂ କାହିଁବେ ନାହିଁବେ

Нийслэлийн Засаг даргын 2025 оны  
01 сарын 01-өдрийн  
161 дүгээр хавсралт  
Захирамжийн  
дүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ  
ХИХ УДИРДАМЖ

Нэг.Зорилго

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилт, бодлогын зорилт, тэдгээрийн төлөвлөлт, тайлагналт болон архив, албан хэрэг хөтлөлт, дотоод ажлын хэрэгжилтийн байдалтай танилцан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж чиглэл өгөх, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх, илэрсэн алдаа дутагдлуудыг арилгуулах зорилготой.

Хоёр.Үндэслэл

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр хурлаас өгөгдсөн үүрэг даалгавар.

Гурав.Чиглэл.

3.1.байгууллагуудын дүрмээр хүлээсэн үүрэг, үндсэн үйл ажиллагааны бүтээмжийн байдал;

3.2.бүтэц зохион байгуулалт, орон тоо, чиг үүргийн давхардал, хийдэл, албан хаагчдын ажлын ачаалал, албан тушаалын тодорхойлолт;

3.3.ажилтан, албан хаагчдын мэдлэг боловсролыг хөгжүүлэх сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил;

3.4.нийслэлийн удирдлагаас өгсөн цаг үеийн үүрэг даалгавар, түүний гүйцэтгэл;

3.5.салбарын хэмжээнд, байгууллагын түвшинд шинээр санаачлан хэрэгжүүлсэн ажил, үр дүн;

3.6.мэдээллийн ил тод байдлыг холбогдох хууль, тогтоол, захирамжийн дагуу хангулан ажилласан байдал;

3.7.байгууллага, нэгжийн болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө түүний тайлагналт;

3.8.хүний нөөцийн бүрдэл, бүрэлдэхүүн, алба хаагчдын нийгмийн асуудал, ёс зүйн чиглэлээр хийсэн ажил;

3.9.иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг хуулийн хугацаандaa шийдвэрлэж буй эсэх, архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт хангаждаж байгаа эсэх, Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн "Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай "165 дугаар тогтоолын хэрэгжилт.

**Дөрөв.Хамрагдах байгууллага, нэгжүүд**

Нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба хамрагдана.

**Тав.Хугацаа**

Нийслэлийн нутгийн захирагааны байгууллагуудын дотоод үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтыг 2025 оны 02 дугаар сард багтаан зохион байгуулна.

Зургаа.Зохион байгуулалт.

6.1.Байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын үр дүнг ажлын хэсгүүд нь ажлын танилцуулга, дүгнэлтээ нэгтгэн нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулна.

6.2.Ажлын хэсгийн гишүүн бүр тодорхой чиг үүрэгтэй ажиллана.

6.3.Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга гишүүдийн илтгэх хуудсыг нэгтгэж, нэгдсэн танилцуулгыг бэлтгэнэ.

6.4.Байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын ажлын танилцуулгад тухайн жилд хийсэн ажлын ололт амжилт; алдаа дутагдал. анхаарах зүйлс, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тусгаж, үр дүн, дүгнэлт зөвлөмжийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж, ажлын хэсгийн ахлагч болон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Дүгнэлтийн бодит байдлыг тухайн ажлын хэсэг хариуцна.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны  
сарын 1-ний өдрийн  
захиргааны удирдлагын газрын  
2 дугаар хавсралт

ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, НИЙСЛЭЛИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГУУДЫН (ХЭВТЭЭ)  
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын  
дарга

Ажлын хэсгийн дэд дарга:

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Гишүүд:

Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний  
нөөцийн хөгжлийн хэлтсийн дарга

Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газрын  
Улс, нийслэлийн хөгжлийн нэгдсэн бодлого,  
төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн

Төрийн захиргааны удирдлагын газрын  
Байгууллага, салбар хоорондын хамтын  
ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний  
нөөцийн хөгжлийн хэлтсийн Нийслэлийн  
нутгийн захиргааны байгууллагуудын удирдах  
албан тушаалтны хүний нөөцийн асуудал  
хариуцсан ахлах мэргэжилтэн

Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний  
нөөцийн хөгжлийн хэлтсийн Тамгын газрын  
хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах  
мэргэжилтэн

Төрийн захиргааны удирдлагын газрын  
Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн  
Ахлах мэргэжилтэн

Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал  
хариуцсан мэргэжилтэн

Төрийн захиргааны удирдлагын газрын  
Захиргаа, дотоод асуудал хариуцсан  
мэргэжилтэн

Төрийн захиргааны удирдлагын газрын  
Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн  
Иргэдийн өргөдөл, гомдол, уулзалтын  
шийдвэрлэлт хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Архивын газрын Төлөвлөлт, мэргэжлийн удирдлагын хэлтсийн дарга

Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын Нийслэлийн удирдах ажилтнуудын зөвлөгөөн, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийн хэрэгжилт, үр дүнд хийх хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Төрийн захиргааны удирдлагын газрын Дүүрэг, хороо хариуцсан мэргэжилтэн

Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн Хүний нөөцийн судалгаа, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн